



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 06 сарын 13 өдөр

Дугаар А/217

Чингис хот

Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах
албанаас халах, цэргийн албыг биеэр дүйцүүлэн
хаах албанд авах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 30 дугаар зүйлийн 30.1.6, Цэргийн албаны тухай хуулийн 29, 30 дугаар зүйл, Засгийн газрын 2018 оны 80, 2018 оны 79 дүгээр тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдын Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 33 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2016-2018 онд Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж хугацаа дууссан иргэдийн нэрийн жагсаалтыг хавсралтаар баталж, Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах албанаас халсугай.

2. Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах албанд элсэх өргөдөл, хүсэлт гаргаж Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдын Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоор батлагдсан иргэдийг Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах албанд авсугай.

3. Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах албанд авсан иргэдийн алба хаах хугацаа, үүрэг гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Цэргийн штабын дарга /дэд хурандаа Н.Хүрэлээ/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА